



ДУНДГОВЬ АЙМАГ  
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 1/18

Тавин

Хязгаарлалтын дэглэм  
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, Аймгийн мал эмнэлэг ариун цэврийн лабораторын 2023 оны 02 сарын 14-ны өдрийн шинжилгээний хариуг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Өвөр-Урт багийн нутаг Хажуу гэдэг газар "Галзуу" өвчний голомт үүссэн тул 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Гоц халдварт Галзуу өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Очирбат)-д даалгасугай.

3. Хязгаарлалтын бүсийн хүн, малын хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Б.Өнөрболд), Багийн Засаг дарга (Б.Төмөрчөдөр) нарт үүрэг болгосугай.

4. Хязгаарлалтын бүсэд хийгдэх халдваргүйтгэл, дархлаажуулалтыг чанартай зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт, шаардлагатай мал сүргийг бүрэн хамруулахыг Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Ард иргэд, малчдад Галзуу өвчний талаарх урьдчилан сэргийлэх сургалт, мэдээ мэдээллийг хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг, Багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ